



ГЛОБ ИНТЕРНЭШНЛ ТББ

Энэхүү сонин бичгийг “Үзэл бодлоо илэрхийлэх зөрчлийн мониторинг ба хараат бус хэвлэл мэдээллийн эрхийг дэмжих нь” төслийн хүрээнд “Глоб Интернэшнл” ТББ-аас 2 сар тутамд эрхлэн гаргана.

Энэ дугаарт

Сэтгүүлчид цагдан хяналтын тухай

Хоёрдугаар нүүр

Цагдан хяналтын (цензур)-ын хэлбэрүүд

Гуравдугаар нүүр

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн бие даасан хараат бус байдал
Цагдан хяналт бодитой байгааг 100 хувь хүлээн зөвшөөрсөн байна

Дөрөвдүгээр нүүр

Шведийн хэвлэлийн Омбудсмен хэрхэн ажилладаг вэ?

Тавдугаар нүүр

Цагдан хяналтын эсрэг хамтдаа

Зургадугаар нүүр

Олон нийтийн нэвтрүүлгийн хуулийн хэрэгжилт

Долдугаар нүүр

Нийтлэлийн жам ёсон

...Нийтлэл бүхэн кино, жүжиг, өгүүллэг, тууж, яруу найраг шиг өөр өөрийн оноосон (нэр) гарчигтай, эхэлбэртэй, эх биетэй, дуус-гавартай. Тэдгээр нь амьдрал дээр ус агаар шиг бэлэн байдаггүй учраас бичигч түүнийг бүтээлч сэтгэлгээний эрэл хайгуулаар олж авдаг...

Наймдугаар нүүр

Сонин бичгийг онлайн болон хэвлэмэл хэлбэрээр авч унших сонирхолтой хүмүүс дараах хаягаар холбоо барина уу.

Манай хаяг: Соёлын төв өргөө, Г корпус, 3 давхар, Улаанбаатар 210620-А

Утас: Э-шуудан
324627 globe@magicnet.mn
324764 globe@globeinter.org.mn
99276253 garav@globeinter.org.mn
bayan@magicnet.mn

Редакцийн зөвлөл:

- Д.Мөнхбүрэн
- Г.Нарангарав
- Х.Цэвэлээ



байгууллага, сэтгүүлчдэд торгууль ноогдуулах, мөрдөн мөшгөх, үйл ажиллагааг нь таслан зогсоох, улмаар сэтгүүлч, зохиолч, уран бүтээлчдийг айлган дарамтлах, эрх чөлөөнд нь халдах, цагдан хорих, амь насыг нь бүрэлгэх зэрэг Хэвлэлийн эрх чөлөөний эсрэг гэмт үйлдэл гарсаар байгааг олон нийтэд мэдээлэх, нэхэн сануулах үүднээс энэ өдрийг тэмдэглэх болсон юм.

Энэ өдөр хэвлэлийн эрх чөлөөнд хүндэтгэлтэй хандах ёстойг улс орны Засгийн газруудад, мөн хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудад өөрсдөд нь хэвлэлийн эрх чөлөөний мөн чанарыг ухамсарлах, мэргэжлийн ёс зүйгээ дээдлэх ёстойг сануулдаг юм.

Мэдээ ♦ Мэдээ ♦ Мэдээ

Сэтгүүлчид Шведийн хэвлэл мэдээллийн орчны тухай

Одоогоос 240 жилийн өмнө үг хэлэх, хэвлэн нийтлэх эрхээ хуульчлан тогтоосон оронд бусдад үзүүлэх, харуулах туршлага байх нь гарцаагүй юм байна. Ард түмний сонгосон төрийн үйл ажиллагааг олон нийтэд бодит байдлаар нь хүргэхийн тулд энэ талаарх мэдээлэл, баримтыг цуглуулах нь (тодорхой цөөн тооны мэдээллээс бусад нь) сэтгүүлчдэд нээлттэй байж чаддаг нь “баялаг” мэт санагдлаа. Засгийн газрын Ерөнхий сайдад ирсэн захидлыг жирийн иргэн хэн ч үзэх эрх олгогдсон нь төр өөрөө “олон түмнийх” гэдгийг шууд нотолно.

<http://www.globeinter.org.mn/newsdetail.php?nid=230>



Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлтэй танилцаж байна

ХЗДХЯ 2006 оны ажлын төлөвлөгөөндөө “Мэдээллийн эрх чөлөөний тухай” хуулийн төслийг боловсруулахаар тусгасан бөгөөд тус яамны удирдлага хуулийн төсөлтэй танилцаж байгаа гэж хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн ажилтан Д.Саранчимэг яриу. Удирдлага хуулийн төсөлтэй танилцаж, санал оруулсны дараа шүүх, прокурор яам тамгын газарт тарааж, тэдний саналыг тусгаад Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, УИХ-д өргөн барих аж.

Дэлгэрэнгүйг <http://www.globeinter.org.mn/newsdetail.php?nid=214>

Мэдээлэл авах эрхийн тухай лекц уншив

Байгаль орчныг хамгаалах чиглэлээр ажилладаг “Ариун суварга хөдөлгөөн” ТББ 2006 оны гуравдугаар сарын 23-25-ны хооронд Архангай аймгийн Өлзийт, Батцэнгэл, Өгийнуур суманд байгаль орчныг хамгаалах, усны зүй зохистой хэрэглээг нэмэгдүүлж, булаг шанд, гол горхио хайрлан хамгаалах, мэдээлэл авах эрхийг хуулиар хэрхэн хангасан байдаг талаар иргэд, албаны хүмүүст сургалт семинар зохион байгуулав.

Сургалтын үеэр “Глоб Интернэшнл” ТББ-ын хуульч Г.Даваахүү “Мэдээллийн эрх чөлөө, мэдэх эрх” сэдвээр мөн Шинжлэх Ухааны Академийн Гео экологийн хүрээлэнгийн Усны шинжилгээний лабораторийн эрхлэгч доктор Ч.Жавзан “Дэлхийн болон Монгол улсын усны нөөц, чанар, зөв зохистой хэрэглээ, түүнийг хамгаалах” сэдвээр тус тус лекц уншив.

<http://www.globeinter.org.mn/newsdetail.php?nid=211>



СЭТГҮҮЛЧИД ЦАГДАН ХЯНАЛТЫН ТУХАЙ

МУОНРТ-ийн ММ агентлагийн тоймч Ц.Мөнхтөр

Төр засгийн албан тушаалтнууд эрх ашгийг нь хөндсөн, булхайг нь илчилсэн мэдээлэлд эмзэглэн тухайн мэдээллийн хэрэгслийг хаах, хэвлэлийн эрх чөлөөнд нь халдах зэргээр редакцийн хараат бус байдалд нөлөөлж байгааг цензур гэж ойлгож байгаа. Тухайн мэдээллийн хэрэгслийн удирдлага, редактор, оршин тогтнох эдийн засгийн үндсээр нь дамжуулан хяналт тогтоох оролдлого хаа сайгүй байна.



Мэдээллийн хэрэгслийн редакц нь ямар нэг бүлэглэлийн эрх ашигт хуваагдсан гэж би ойлгодог. Зөвхөн засгийн газрын харьяанд байгаа телевизэд ч биш, өнгөн дээрээ чөлөөт мэт харагддаг зарим арилжааны телевиз хөрөнгө оруулагч болон түүнийг дэмжигч улс төрийн хүчнийхний мэдэлд байдаг. Энэ нь тухайн мэдээллийн хэрэгслийн нийтлэлийн бодлогоос илт байдаг. Нөгөөтэйгүүр хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь олигархуудын хоорондын тэмцлийн талбар болсон.

Хэдийгээр сэтгүүлчид үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй болсон ч хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжиж гарч байгаа материалын цаана хэний нөлөөлөл байгаа нь асуултын тэмдэг хэвээр байна.

“Ардын Эрх” сонины сэтгүүлч Л.Мөнхбаясгалан



Цагдан хяналт гэхээр заавал шоронд хийгээд барьж хорьсноор илрэхгүй байх. Сэтгүүлчийн ажиллах нөхцөл бололцоог олгохгүй, бичих гэж буй материалыг нь тухайн сонин хэвлэлд гаргахгүй, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг нь боогдуулахыг цагдан хяналт гэж ойлгож байгаа. Хэдэн жилийн өмнө барьж хорих, шоронд хорихыг цагдан хяналт гэж ойлгож

байсан бол сэтгэл санааны дарамт, эрх чөлөөг нь боогдуулах, ажил хийхэд нь саад учруулах зэргийг цагдан хяналтын хэлбэрүүд гэж ойлгох болсон.

2004 оноос хойш цагдан хяналт маш их ихэссэн. Өмнө нь хувьсгалт нам дангаараа эрх барьж байх үед сонинг хаасан, сэтгүүлчийг хорьсон зэрэг хоёр гурван тохиолдол гарч, цагдан хяналт байсан. Гэхдээ 2004 оноос хоёр улс төрийн хүчин УИХ-д тэнцүү суудал авсны дараа цагдан хяналт улам нэмэгдсэн. Шоронд хорих бус эрх чөлөөг нь боогдуулах, сэтгэл зүйн дарамт үзүүлэх, ажлаа хийхэд нь саад болох, сонин телевизийн эздийг атгандаа авах зэргээр цагдан хянах ажиллагаа 2004 оноос хойш ихэссэн. Миний хувьд өдөр тутам цагдан хяналттай тулгардаг.

МУОНРТ-ийн “Гараг” продакшны захирал Г.Бадамсамбуу



Хэн нэгний үзэл бодол, эрх ашигт нийцүүлэн мэдээллийн үнэн бодит байдлыг гуйвуулахыг цензур гэнэ. Төр засаг, ажил олгогч сэтгүүлчдийн үйл ажиллагаанд цензур тогтоохоос гадна сэтгүүлч өөрөө үйл явдлын бодит байдал, мэдээллийг цензурддэг. Үйл явдлыг үнэн зөв, шуурхай, тэнцвэртэй мэдээлэх нь сэтгүүлчийн үүрэг байдаг ч тэд ямар нэг нөлөөнд автсан, мэргэжлийн ур чадвар дутсанаас үйл явдлын бодит байдлыг өөрийн үзэл бодлоор гуйвуулах эсвэл дутуу мэдээлэлтэйгээс болж тухайн асуудалд буруу өнцгөөс хандах зэргээр цензур тогтоодог. Сэтгүүлч өөрийн үзэл бодлоор бодит байдлыг гуйвуулна гэдэг хамгийн аюултай цензур.

Нөгөөтэйгүүр хэвлэл мэдээллийн эрх баригчид бодит байдлыг цензурдэх, мэргэжлийн эрхэнд халдах байдал хэвээр байгаа. Сэтгүүлчийн бичсэн мэдээ нийтлэлийг хэвлэл мэдээллийн хэрэгслийн удирдлага мөн түүнд нөлөөлдөг улс төр, бизнесийн бүлэглэлүүдийн эрх ашигт нийцүүлэн цензурдэх хандлага байна. Жишээ нь хувийн шар сонинд эзний болон тодорхой бүлэглэлийн эрх ашгийг

хөндсөн мэдээлэл тавьж болохгүй. Тэгэхлээр энэ сонины удирдлага болоод тодорхой бүлэглэлүүд сэтгүүлчдийн үйл ажиллагаанд цензур тогтоож байгаа гэсэн үг юм. МУОНРТ-д сэтгүүлчийн мэргэжлийн эрх ашгаас илүү хүмүүсийн үзэл бодол, эрх ашигтай холбоотой цензур бий. Хэдийгээр Монголын Үндэсний Телевиз олон нийтийнх болох гэж байгаа боловч олон нийтийн телевизийн Үндэсний Зөвлөл нь намын бүлэглэлүүдийн эрх ашгаар хуваагдчихсан, тэр үзэл бодол нь Ерөнхий захиралдаа нөлөөлдөг. Ерөнхий захирлын улс төрийн болоод үзэл бодол нь энэхүү бүтцээр дамжин илрээд байгаа.

Бэлтгэсэн: Вэб редактор Г.Нарангарав

Монголын Хэвлэлийн Хүрээлэнгийн сэтгүүл зүйн багш Р.Оюунцэцэг

Манайд эзэн эрхлэгч хоёрын ажил үүргийн хуваарийг нарийн зааглаагүйгээс цагдан хяналт илэрч байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэн сонины бодлогод оролцож, тухайн хэвлэлд ямар материал нийтлэхийг зааж, зааврлах зэрэг эрхлэгчийн ажилд шууд оролцох хандлага их ажиглагдаж байна.

Энэ л шалтгааны улмаас бүр доод шатандаа сэтгүүлч ямар сэдвээр бичих тухайд эзэн орлцож байна. Үүгээр ч зогсохгүй тухайн сонины санхүүжүүлэгч хүртэл нийтлэлийн бодлогод нөлөөлсөөр байна.

Барууны сэтгүүл зүйд эзэн, эрхлэгчийн ажил үүргийг редакцийн баримтлах зарчмаар заагласан байдаг. Эрхлэгч сонины бодлогоо хариуцаж, эзэн эрхлэгчийн ажилд оролцохыг хориглодог.

Ажил үүргийн хуваарийг зааглах юм уу ёс зүйн хатуу шалгуур тавьж өгөх талаар тодорхой ярьсан зүйл байхгүй болохоор манай нөхцөлд эзэн, редакцийн ажил холилдож байж болох юм. Эзэнээс хамааралтай байгаа нөхцөлд үүнтэй тэмцэхэд их түвэгтэй.



“25 суваг” телевизийн захирал З.Алтай




Хэвлэл нийтлэх эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө манайд байна. Гэхдээ аливаа юм бол хязгаартай байх ёстой. Хүний нэр төрийг гутаах, улс орны эрх ашигт ноцтой хор хохирол учруулахаар бол хэвлэл мэдээллийн байгууллага сэтгүүлчдийн үйл ажиллагааг шалгах ёстой. Сэтгүүлч бүрэн эрхтэй гэсэн

утаар хандаж болохгүй. Хуулийн хүрээнд хийсэн ажилд манайх цензур тавьдаггүй. Хариуцлагыг өндөржүүлэхэд дотоод хяналт байна.

Манай байгууллагад төр засгаас ямар нэг дарамт шахалт үзүүлсэн юм байхгүй. Зарим хэвлэл мэдээллийн байгууллагад түүнийг үүсгэн байгуулсан хүмүүсийн эрх ашиг, үзэл бодол, сонирхол гэх мэт дарамт байхыг үгүйсгэхгүй. Одоохондоо манай телевизэд төрөөс ямар нэг дарамт шахалт үзүүлсэн тохиолдол байхгүй. Гэхдээ өмнөх УИХ-ын сонгуулийн үед төр засгаас шууд бус байдлаар дарамт шахалт үзүүлж байсан. Төрийн эрхэнд хэн гарахаас хамаараад дарамт шахалт гарахаар юм билээ. Үүнийг өөрийн биеэр мэдэрсэн.

ЦАГДАН ХЯНАЛТ (ЦЕНЗУР)-ЫН ХЭЛБЭРҮҮД

ХМХ-ийн хараат бус байдал хамгийн халгаатай зүйл бол цагдан хяналт-цензур юм. Энэ бол иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлаж буй хамгийн хатуу хэлбэр юм.



Төрийн цагдан хяналт

Төрийн цагдан хяналт гол төлөв хуулиар дамжин илэрдэг.

- Төрийн нууцын хуулийг цагдан хяналт болгон ашиглах

Монгол Улсад Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалтын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль үйлчилдэг. Мөн бараг бүх хуульд мэдээлэл нууцлах тухай зүйл заалт бий. Монголд мэдээлэл олж авах үнэмлэхүй эрхтэй хүмүүс бол аудиторууд юм.

- Нэр төр, гүтгэлэгтэй холбоотой Эрүүгийн хуулийн хатуу чанга заалтыг цагдан хяналт болгон ашиглах
- Сонин хэвлэлхгүй байх үүрэг даалгавар өгөх
- ХМХ-ийн эрхлэгч, дарга нарыг үндэслэлгүй ажлаас нь халах
- Сонин хэвлэлийн түгээлтийг саатуулах, хязгаарлах
- Өргөн нэвтрүүлгийг зогсоох, саатуулах, хязгаарлах

Захиргааны аргаар цагдан хянах

- Хууль тогтоомжид нийцээгүй, сэтгүүлч, ХМХ-ийн эрхийг хязгаарласан дүрэм, журам гаргах
- Төрийн албан хаагчид элдэв төрлийн дүрэм, журмыг ашиглан дарамт шахалт үзүүлэх (хурал, цуглаанаас хөөх, байгууллагад нэвтрүүлэхгүй байх)
- Сурвалжлагчид итгэмжлэх үнэмлэх олгохгүй байх, хураан авах
- Зураг авах, бичлэг хийх боломж олгохгүй саатуулах
- Бусад

Эдийн засгийн аргаар цагдан хянах

- Өндөр татвар ногдуулах
- Цаас, хэвлэлийн материалыг хил дээр саатуулах
- Их хэмжээний торгууль ногдуулах
- Төрийн мэдлийн байр түрээсэлж буй бол түрээсийн үнийг үндэслэлгүйгээр өсгөх
- Редакцийн эд хогшилд халдах
- Дансыг үндэслэлгүйгээр шалгах, хаах
- Байн байн татвар, нийгмийн даатгалын шалгалт оруулах
- Бусад

Айлган сүрдүүлэх нь

Сэтгүүлч ажил үүргээ гүйцэтгэж явахдаа олон хэлбэрийн хүчирхийлэлд өртдөг. Сэтгүүлчдийн хүчирхийллийн эсрэг тэмцэх нь ардчилсан төр, засгийн үүрэг бөгөөд чөлөөт хэвлэлийн баталгаа болсон хууль тогтоомж бүтцийг бий болгож өгөх нь чухал байдаг.

Сэтгүүлчдийн эсрэг хүчирхийлэл нь хатуу цагдан хяналтын нэг хэлбэр юм.

- ХМХ-ийг ялгаварлан гадуурхах (өөрт таалагддаг зарим сэтгүүлчийг эсвэл өөрт ойр, эсвэл өөрийн эзэмшилд байдаг ХМХ-ийг илүү мэдээллээр хангах, засгийн газрын сурталчилгааг зөвхөн тэдгээрт өгөх гэх мэт)
- ХМХ-д хатуу хязгаарлалт тогтоох (сонины цаасны хэмжээнд хязгаарлалт тавих, ХМХ, шууданд онцгой татвар ногдуулах, радио, телевизийн долгионд хязгаарлалт тавих, электрон шуудан, интернетээр үзэл бодлоо илэрхийлэх боломжийг хязгаарлах гэх мэт)
- Сэтгүүлч, ХМХ-д лиценз, зөвшөөрөл олгохтой холбогдуулан сүрдүүлэх
- Сэтгүүлчдийг мэдээллийн эх сурвалжаа илчлэхийг шаардах, татгалзсаных нь төлөө торгох, шоронгоор айлган сүрдүүлэх
- Төр, засгийн газрын албан тушаалтнууд сэтгүүлчдийг дуудаж, загнах, шаардлага тавих, зааж зааварчлах
- Улс төрч, албан тушаалтнуудын буруу үйлдлийг илчлэн үнэнийг бичсэнийх нь төлөө нэр төр, гүтгэлгийн хатуу хууль, зүйл заалтаар далайлган сүрдүүлэх
- Сэтгүүлчийн нэр хүндэд халдах
- Сэтгүүлч, тэдний ойр дотны хүмүүсийн эрүүл мэндэд халдах, алахаар заналхийлэх
- Сэтгүүлч, тэдний ойр дотны хүмүүсийн амь насанд нь халдах

Редакцийн цагдан хяналт

ХМХ-ийн эзэд, эрхлэгч, редакторууд сурвалжлагч, ажилтнуудынхаа өдөр дутмын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох ёсгүй. Үүнийг редакцийн хараат бус байдлыг хангах гэрээ, баримт бичгээр баталгаажуулах ёстой. Энэ бол хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын нэг хэсэг юм.

- ХМХ-ийн эзэд, эрхлэгч, редакторууд сурвалжлагч, ажилтнуудынхаа бичсэн, бэлтгэсэн материалын агуулгыг хянах
- Сурвалжлагч, ажилтнуудынхаа бичсэн, бэлтгэсэн материалыг тодорхой зорилгоор нийтлэхгүй, нэвтрүүлэхгүй байх
- “Болохгүй” гэж үзэж буй хэсгээ хасахыг шаардах
- Цалин хасах, ажлаас халах зэргээр арга хэмжээ авах, шийтгэл ногдуулах
- Элдвээр загнах, зүхэх зэргээр дарамтлах
- Бусад



Сэтгүүлч өөрийгөө цагдан хянах нь

Үүнээс хамгийн аюултай цагдан хяналт нь өөрийн цагдан хяналт юм. Энэ нь “Сэтгүүлч аливаа айдас хүйдэст автан өөрийгөө цагдан хянах”-ыг хэлнэ. Энэ нь сэтгүүлч, редакторууд тухайн ХМХ-ийн эзэн, түүнтэй ойр холбоотой хүмүүсийн, эсвэл бизнесийн ашиг сонирхолыг хөсөрдүүлэхээс эмээсэндээ тодорхой сэдвийг хөндөхгүй байх, улс төр, эрх баригчдын дарамт шахалтаас айж, тэдний тухай шүүмжлэлт материал нийтлэх, нэвтрүүлэхээс айх зэргээр илэрдэг.

Бэлтгэсэн: “Глоб Интернэшнл” ТББ-ын тэргүүн, сэтгүүлч Х.Наранжаргал

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН БИЕ ДААСАН ХАРААТ БУС БАЙДАЛ

Олон нийт үнэн бодитой мэдээлэл хүлээж авах эрхтэй. Олон нийт мэдээлэл хүлээж авах хамгийн түгээмэл, хүртээмжтэй хэлбэр нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүлээн авах юм. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн түгээж байгаа мэдээлэл нь үнэн бодитой байхын тулд хөндлөнгийн оролцоо цензургүй байгаа тохиолдолд үнэн бодитой байх магадлалтай юм. Энэ байдлыг хангахын тулд Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг батлан гаргажээ. Уг хуулийн 2 дугаар зүйлд “Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно”, 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт/цензур/ тогтоохгүй”, 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд хяналт тавих байгууллага байгуулахгүй бөгөөд ийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй”, 4 дүгээр зүйлд “Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно” гэж заасан байна.

Энэ хуулийг хэрэгжүүлэх үүднээс тухайн үед төрийн мэдэлд байсан “Ардын эрх” сонин, “Засгийн газрын мэдээ” сонинуудыг хувьчилсан, мөн 2005 оны 1 сарын 27-ны өдөр Олон нийтийн радио, телевизийн тухай, Төрийн өмчөөс олон нийтийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай хуулийг батлан гаргасан бөгөөд Монголын үндэсний радио телевизийн хэрэг эрхлэх газрыг татан буулгаж Олон нийтийн радио, телевизийг үүсгэн байгуулсан юм.

Гэтэл Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Нийслэл Улаанбаатар хот нь өөрийн сонин, телевиз болон радиогийн нэвтрүүлэгтэй байж болно” гэсэн заалт, мөн Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлд “Хот тосгоны өөрийн мэдлийн радио, телевизийн байгууллагын үйл ажиллагааг чиглүүлнэ”, мөн уг хуулийн 34 дүгээр зүйлд “Хот сонин,

сэтгүүл, радио, телевизтэй байж болно” гэсэн заалтууд нь шууд Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хуультай зөрчилдөж байна. Гэхдээ энэ байдлаас гарах гарц буюу дээрх Нийслэлийн эрх зүйн байдлын тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиудын хэвлэлийн эрх чөлөөг үндэслэлгүйгээр хязгаарласан заалтуудыг шүүхийн практикт хэвлэл мэдээллийн байгууллагын эсрэг хэрэглэхгүй байх боломжтой юм. Яагаад гэвэл Монгол Улсын Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуулиас бусад хууль хоорондоо зөрчилдвөл тухайн асуудлыг илүү нарийвчлан зохицуулсан хуулийн, тийм хууль байхгүй бол сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийн заалтыг хэрэглэнэ” гэсэн байна. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль хоёроос Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хууль нь сүүлд батлагдан гарсан учраас дээрх хэвлэлийн эрх чөлөөг хязгаарласан заалтуудыг хэрэглэхгүй байх боломжтой юм.

Хэвлэлийн хүрээлэнгээс хийсэн судалгаанаас үзэхэд 2004 оны эцсийн байдлаар төрийн мэдэлд 19 телевиз, үүнээс үндэсний хэмжээнд нэвтрүүлгээ цацдаг 1 телевиз, Улаанбаатар хотын хэмжээнд нэвтрүүлгээ цацдаг 1 телевиз, хөдөө, орон нутагт нэвтрүүлгээ цацдаг 17 телевиз байна. Энэ тоо баримт нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн хэрэгжилт ямар түвшинд байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, 1998 онд Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль батлагдсанаас хойш 2004 он хүртэл 6 жилийн хугацаа өнгөрөхөд төрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд байсаар байжээ. Гэхдээ энэ судалгаанд дурдсан үндэсний хэмжээнд нэвтрүүлгээ цацдаг телевиз буюу Монголын үндэсний радио, телевизийн хэрэг эрхлэх газрыг татан буулгаж Олон нийтийн радио, телевизийг үүсгэн байгуулсан нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг хэрэгжүүлэх нааштай том алхам болжээ.


Бэлтгэсэн: Хуульч Г.Даваахүү

ЦАГДАН ХЯНАЛТ БОДИТОЙ БАЙГААГ 100 ХУВЬ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН БАЙНА


Манай байгууллага 2004 оны УИХ-ын сонгуулийн үеэр мэдээ, нийгэм, улс төрийн чиглэлээр идэхтэй ажилладаг 200 сэтгүүлчдийн дунд судалгаа хийсэн юм.

Судалгаанд хамрагдсан сэтгүүлчид Монголд цагдан хяналт бодитой байгааг 100 хувь хүлээн зөвшөөрсөн бөгөөд 87.3 хувь нь эрх барьж буй намын зүгээс, 12.7 хувь нь сөрөг хүчний зүгээс, 8 хувь нь ХМХ-ийн эздийн зүгээс цагдан хянадаг гэсэн ба 0.2 хувь нь бусад хэлбэрийн цагдан хяналт байдаг гэжээ. Мөн сэтгүүлчид 100 хувь өөрийгөө цагдан хянадаг гэдгээ хүлээн зөвшөөрсөн байна.

Цагдан хяналтын тухай
/хувиар/



Өөрийн цагдан хяналтын шалтгаан
/хувиар/



ШВЕДИЙН ХЭВЛЭЛИЙН ОМБУДСМЭН ХЭРХЭН АЖИЛЛАДАГ ВЭ?

Эрх мэдэл самууруулдаг. Онцгой эрх мэдэл онцгой самууруулдаг. Тиймээс ардчилсан нийгэмд янз бүрийн эрх мэдлийг харилцан тэнцвэржүүлж, хянаж шалгаж чаддаг тогтолцоо бий болгох хэрэгтэй. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл нь шалгадаг, гэхдээ өөрөө ч хяналтад байх учиртай.

Хэрвээ сэтгүүл зүй өөрийгөө хянадаг бол илүү сайн байхсан билээ. Сонин, бусад олон нийтийн мэдээллийн хэрэгсэл бие биедээ шүүмжлэлтэй хандаж, өөрсдөө хэвлэлийн ёс зүйн зарчмыг бий болгодог.

/Эрик Багерстам "Ардчилсан нийгэм дэх хэвлэлийн эрх чөлөө" хэвлэлийн ёс зүйн ширээний номоос/.

ШВЕДИЙН ХЭВЛЭЛИЙН ОМБУДСМЭНИЙ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ Өөрийн зохицуулалт хэрхэн ажилладаг тухай

Шведийн хэвлэлийн өөрийн зохицуулалтын систем нь хууль, дүрэм журамд тулгуурладаггүй байна. Хэвлэлийн өөрийн зохицуулалтын газар нь Шведийн сонины хэвлэн нийтлэгчдийн холбоо, Сэтгүүлийн хэвлэн нийтлэгчдийн холбоо, Шведийн сэтгүүлчдийн холбоо, Үндэсний хэвлэлийн клуб зэрэг хэвлэлийн дөрвөн байгууллагаас бүрэн санхүүждэг, сайн дурын үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулдаг байгууллага юм. Эдгээр дөрвөн байгууллага Шведийн хэвлэл мэдээллийн байгууллага, радио болон телевизийн ёс зүйн кодыг боловсруулах үүрэгтэй.

Шведийн Хэвлэлийн консул нь 1916 онд байгуулагдсан бөгөөд дэлхийн ийм төрлийн шүүх байгууллагын хамгийн эртнийх нь аж. Хэвлэлийн консул нь тус байгууллагыг даргалдаг шүүгч, мөн дээр дурдсан хэвлэлийн дөрвөн байгууллага тус бүрээс нэг төлөөлөгч, сонины бизнес болон хэвлэлийн байгууллагатай ямар нэг холбоогүй олон нийтийн гурван төлөөлөгчөөс бүрддэг байна.

Хэвлэлийн Омбудсмэний алба 1969 онд байгуулагдсан. Үндэсний хэвлэлийн клубын дарга, Шведийн хуульчдын холбооны дарга, Парламентын Омбудсмэний дарга нараас бүрдсэн тусгай хороо Хэвлэлийн Омбудсмэнийг томилдог. Хэвлэлийн Омбудсмэний алба байгуулагдахаас өмнө сайн сэтгүүл зүйн зөрчилтэй холбоотой гомдлыг Хэвлэлийн консул шийдвэр байсан. Өнөө үед өргөдөл, гомдлыг эхлээд Хэвлэлийн Омбудсмэн авч үзээд, өргөдөл гаргаж байгаа хувь хүнтэй тохиролцдог байна. Хэвлэлийн Омбудсмэн нь өөрийн санаачлагаар аливаа хэргийг авч үзэх эрхтэй.

Сонинд нийтэлсэн материал сайн сэтгүүл зүйг зөрчсөн гэж үзсэн нийгмийн гишүүн хэн боловч Хэвлэлийн Омбудсмэнд гомдол гаргах эрхтэй. Гэхдээ сонинд нийтлэгдсэн мэдээ материалд холбогдсон хүн гомдлын дагуу тухайн сонинг албан ёсоор шүүмжлэхийг зөвшөөрч байгаагаа бичгээр өгнө.

Өргөдөл гомдол хүлээж авсны дараа Хэвлэлийн Омбудсмэн хэвлэлээр залруулга хийх эсвэл шүүмжлэлд өртсөн хүний тайлбарыг сонинд тавих эсэхээ шийдэх үүрэгтэй. Хэвлэлийн Омбудсмэн энэ зорилгоор сонинтой холбоо барьж болно. Маргааныг энэ аргаар зохицуулж чадаагүй мөн сайн сэтгүүл зүйн дүрэм журмыг зөрчсөн гэж сэжиглэж байгаа бол Хэвлэлийн Омбудсмэн байцаалт явуулж болох юм.

Үүний дараа Хэвлэлийн Омбудсмэн сонины хариуцлагатай редакторыг гомдол гаргагчийн буруутгаж байгаа асуултад хариулт өгөхийг шаардах хэрэгтэй. Мөн гомдол гаргасан хүнд сонины хариултанд тайлбар хийх боломж олгоно. Гомдол гаргагч дүрмийн дагуу сонинд нийтлэл гарснаас хойш гурван сарын дотор өргөдөл гаргана.

Байцаалт авч дууссан тохиолдолд Хэвлэлийн Омбудсмэнд шийдвэр гаргах хоёр хувилбар байна. 1. Тухайн хэргээс үүдэн сонинг албан ёсоор шүүмжлэх шаардлагагүй. 2. Цуглуулсан баримт нь Хэвлэлийн Консул шийдвэр гаргах хэмжээнд ач холбогдолтой гэж үзэх.

Хэрэв Хэвлэлийн Омбудсмэн гомдлыг хэрэгсэхгүй /хувилбар 1/ гэж үзвэл гомдол гаргач шууд Хэвлэлийн Консулд давж заалдаж болно. Хэвлэлийн консул болон Хэвлэлийн Омбудсмэн өргөдөл, гомдлыг авч хэлэлцсэний дараа гомдол гаргагч шүүх байгууллагад хандахад ямар ч саад тогтор байхгүй.

Хэвлэлийн Омбудсмэнд гомдол гаргахад үнэ төлбөргүй. Хэвлэлийн Омбудсмэн хэвлэлийн ёс зүйн асуудлаар олон нийтийн тавьсан асуултанд хариулдаг.

Сайн сэтгүүл зүйн дүрэм журмыг зөрчсөн сонин Хэвлэлийн Консулын бичгээр гаргасан шийдвэрийг нийтэлнэ. Энэ сонин захиргааны арга хэмжээний торгууль төлөх ёстой.

Өнгөрсөн жилүүдэд жил тутам 350-400 гомдол бүртгэж авсан байна. Гомдлын дийлэнх нь хувийн нууцад халдсан, гэмт хэргийн асуудалтай холбоотой байгаа юм. Хэвлэлийн Омбудсмэний хүсэлтээр мөн түүний хэрэгсэхгүй гэж үзсэн хэргээр гомдол гаргагч давж заалдсанаар нийт гомдлын 30 орчим хувийг Хэвлэлийн Консул авч үзсэн байна. Гаргасан гомдол үндэслэлгүй мөн гомдол гаргагчийн тайлбар, залруулгыг сонинд нийтэлсэн зэрэг олон шалтгааны улмаас нийт гомдлын 70 орчим хувийг хэрэгсэхгүй болгожээ. Нийт гомдлын 10-15 хувьд Хэвлэлийн Консулын шийдвэрээр сонинг албан ёсоор шүүмжилсэн байна.

Бэлтгэсэн: Вэб редактор Г.Нарангараа

Угс	Байгууллагын нэр	Байгуулагдсан он сар	Үүсэн байгуулагчид	Байгууллагын зорилго	Бүтэц	Санхүүжилт	Эрх мэдэлтний оногдуулсан хориг
Англи	Хэвлэлийн асуудал эрхэлсэн зөвлөл	1961	Хэвлэн нийтлэгчийн эвлэл, Австрийн сэтгүүлчдийн холбоо	Хэвлэл мэдээллийн байгууллага нь мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ, холбогдох хууль тогтоомжоо мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих, хэвлэлийн эрх чөлөө болон хуулиар олгосон эрхийг хамгаалах, олон нийт, тээвэр, парламентын өмнө хэвлэл мэдээллийн эрх ашгийг хамгаалах	20 хүн: байгууллага тус бүрээс 10 хүн	Хэвлэл мэдээллийн /ХМ/ байгууллагуудаас санхүүждэг	Зөвлөх шинж чанартай шийдвэр гаргана: Зөвлөл ОНМХ-ээс буруутай үйл ажиллагааны талаарх дүгнэлт нийтлэхийг шаардах
Герман	Германы хэвлэлийн зөвлөл	1956	Сонин болон сэтгүүлчдийн холбоо	Хэвлэн нийтлэгч болон сэтгүүлчдийн мэргэжлийн ёс зүйн зарчмыг зөрчсөн талаарх хувь хүмүүсийн гаргасан өргөдөл гомдлыг авч үздэг	Олон Нийтийн Мэдээллийн Хэрэгслийн Төлөөлөгчид	ХМ-ийн байгууллагуудаас санхүүждэг	Зөвлөл энэ зарчмыг зөрчсөн ОНМХ-ийг донгодож, энэ тухай нийтлэхийг шаардах боломжтой
Швед	Хэвлэлийн зөвлөл	1960	ОНМХ	Ёс зүйгүй сэтгүүлчдээс иргэдийг хамгаалах	ОНМХ-ийн чухал байгууллага: 16 хүн: 8 сэтгүүлч ОНМХ-ийн сэтгүүлч бус 8 мэргэжилтэн. Зөвлөлийн тээгүүн, нарийн бичиг нь хуульч байх ёстой	ХМ-ийн байгууллагуудаас санхүүждэг	Зөвлөлгөө өгөх шинжтэй шийдвэр гаргана. Энэ тухай мэргэжлийн сэтгүүлд нийтэлж болно.
Норвег	Хэвлэлийн зөвлөл	1936	ОНМХ		7 хүн: хэвлэлээс-4 Олон нийтээс 3	ХМ-ийн байгууллагуудаас санхүүждэг	Буруутай сонинд Зөвлөлийн шийдвэрийг олны нүдэнд тусах газар нийтэлнэ
Швейцарь	Хэвлэлийн асуудал хариуцсан зөвлөл	1916	ОНМХ	Ёс зүйн зарчмыг хамгаалах	6хүн: олон нийтээс 3 сэтгүүлчдийн байгууллага болон сониноос 3	Торгуулиас	Сониныг донгодож: ногдуулсан тоогуулийн хэмжээг Зөвлөлийн орлогод авна.

Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй: энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах, эрх чөлөө, үзэл санаа мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана /Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал 19 дүгээр зүйл/.

ЦАГДАН ХЯНАЛТЫН ЭСРЭГ ХАМТДАА

**УИХ-аас 2003 онд баталсан “Монгол Улсад
Хүний Эрхийг Хангах Үндэсний хөтөлбөр”-ийн
“Хүний суурь эрхийг хангах нь” хэмээх II бүлэг**

**2.2.5. Мэдээллийн эрх чөлөө, үзэл бодлоо чөлөөтэй
илэрхийлэх эрхийг хангах талаар**

2.2.5.1. Нууц хамгаалах хуулиудаар тогтоосон илүүц хязгаарлалтыг арилгах зэргээр төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны илүү тод байдлыг хангаж, энэ талаар иргэд, хэвлэл мэдээллийн ажилтны хүсэлт шаардлагаар мэдээлэл гаргаж өгөх үүрэг хариуцлага, иргэдээс мэдээлэл олж авах, түгээх эрхийг нь нарийвчлан тодорхойлсон хууль, эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.

2.2.5.2. Олон нийт хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг дэмжин төрийн болон орон нутгийн өмчид байгаа хэвлэл мэдээллийн хэрэгслийн зах зээлийн харилцаанд нийцүүлэн бие даасан байдлыг бэхжүүлэх зохион байгуулалт эрх зүйн арга хэмжээ авна.

2.2.5.3. Хүн амын мэдээлэл хүлээн авах нөхцлийг сайжруулах зорилгоор орон нутгийн харилцаа, холбоо, хэвлэл мэдээллийн сүлжээг шинэтгэн өргөтгөж үйлчилгээг нь хүртээмжтэй болгох, алслагдсан нутгийн хүн амд шуудан, мэдээлэл хүргэх, хүлээн авах, дамжуулах боломжийг сайжруулахаар тухайлан арга хэмжээ авна.

2.2.5.4. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбогдох бүх хууль тогтоомжид судалгаа хийж, зөрчилтэй зүйл, заалтыг хүчингүй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах зэргээр хууль тогтоомжийг боловсронгуй болгоно.

2.2.5.5. Иргэдээс хэвлэл нийтлэх, тайван жагсаал цуглаан хийх зэргээр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, төрийн байгууллага, албан тушаалтан, улс төрчид, нийгмийн зүтгэлтнүүдийн үйл ажиллагааны талаар өөрийн санаа бодол, шүүмж, зэмлэлээ чөлөөтэй илэрхийлэх эрх зүйн хүчтэй баталгаа /зарчим/тогтоохын хамт үндэслэлтэй мэдээллийг ажил хэрэгт тусган хариуцах ёсыг бэхжүүлнэ.

2.2.5.6. Мэдээллийн эх сурвалжаа нууцлан хамгаалах сэтгүүлчийн эрх, үүргийг хуулиар баталгаажуулж, иргэд, хэвлэл мэдээллийн хэрэгслийн ажилтан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэхдээ хүний нэр, нэр төр, алдар хүндийн халдашгүй байх эрхийг зөрчихөөс сэргийлэх, зөрчигдсөн эрхийг нь бүрэн сэргээх эрх зүйн механизмыг тодотгон сайжруулна.

2.2.5.7. Үндэсний цөөнх эх хэлээрээ мэдээлэл авах, түгээх боломжийг хангах арга хэмжээ авна.

2.2.5.8. Мэдээллийн эрх чөлөөний талаархи олон улсын гэрээ, хэлэлцээрийг үргэлжлүүлэн судалж шаардлагатай гэрээ, конвенцид нэгдэн орох асуудлыг шийдвэрлэнэ.

**МОНГОЛ УЛСЫН ИРГЭН
МЭДЭЭЛЭЛ ХАИХ, ХҮЛЭЭН
АВАХ ЭРХТЭЙ**

(Монгол Улсын Үндсэн хуулийн 16.17 хүйс)



**"МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ НЬ
ХҮНИЙ ЯЗГУУР ЭРХ БӨГӨӨД ...
НҮБ-ААС ТУНХАГЛАСАН БҮСАД
БҮХ ТӨРЛИЙН ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ
ХЭМЖИХ ҮНДСЭН ХЭМЖҮҮР МОН"**

(1996 оны 117-н Ерөнхий Ассамблей, 59-р тогтоолын 1 дүг хэсэг)

Уриалга

Олон Улсын Сэтгүүлчдийн Холбооны 21-р Их хурлаас баталсан “Ардчилсан хэвлэл мэдээллийн хэрэгслийн соёлын тунхаг”-т ардчилсан нийгэмд мэдээллийн хэрэгслийн гүйцэтгэх үүрэг онцгой өвөрмөц агаад тухайлсан үүргийг ухаарч сэхээрсэн тэр цагт ардчилал бүрнээ үнэ хүндтэй болох учиртай гэсэн байдаг. Мөн ОУСХ нь хэвлэлийн эрх чөлөө гэдгийг “хөндлөнгийн нөлөөлөл, оролцооноос чөлөөтэй байх явдал мөн” хэмээн тодорхойлсон.

Цагдан хяналт (цензур) бол үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлаж буйн тод илрэл бөгөөд хамгийн ноцтой хэлбэр юм. Монгол Улсад 1998 онд батлагдсан Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиар цагдан хяналт (цензур)-ыг хориглосон. Гэвч “Глоб Интернэшнл” ТББ-аас 2004, 2005 онд сэтгүүлчдийн дунд явуулсан судалгаанд оролцогчид 100 хувь цагдан хяналт бодитой оршоор байгааг хүлээн зөвшөөрч, бүх сэтгүүлч “өөрийгөө цагдан хянадаг” гэж хариулсан нь сэтгүүлчдэд мэргэжлийн ёс зүйгээ баримтлахад нь хүчтэй нөлөөлж, хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд түгшүүр төрүүлж байна.

“Глоб Интернэшнл” ТББ, “Зориг сан” хамтран Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийг тохиолдуулан зохион байгуулсан дугуй ширээний ярилцлагад оролцогчид бид 1987 оны 1-р сарын 16-18-ны өдрүүдэд Лондон хотноо болсон “Дэлхийн эрх чөлөөний дуу хоолой” цагдан хяналтын (цензур) эсрэг бага хурлын төлөөлөгч, 34 орны сэтгүүлчдийн баталсан “Чөлөөт хэвлэлийн харти”, “Ардчилсан хэвлэл мэдээллийн хэрэгслийн соёлын тунхаг” зэрэг баримт бичгийг иш үндэс болгон энэхүү уриалгыг хэлэлцэн батлав.

Монгол Улсын хэмжээнд болон хилийн чанадад мэдээ, мэдээллийг саадгүй түгээх, сэтгүүлчийн үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд явуулах орчинг бүрдүүлэх, олон нийтийн үнэнийг олж мэдэх эрх ашгийг дээдлэн хүндэтгэхийн тулд:

**УИХ, Засгийн газар, Ерөнхийлөгч, төрийн байгууллагын
албан тушаалтнуудад:**

Нэгд: Шууд болон шууд бус аливаа хэлбэрийн цагдан хяналтыг (цензур) хориглосон Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн заалтаа хэлбэрэлтгүй сахин биелүүлэх, мэдээллийг чөлөөтэй цуглуулах, түгээх эрхэд ноцтой хязгаарлалт тогтоосон Төрийн нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Эрүүгийн хуулиа эргэн харж, ардчилсан нийгмийн шалгуур зарчмуудад нийцүүлэх,

Хоёрт: Хэвлэмэл болон өргөн нэвтрүүлгийн мэдээллийн хэрэгслийн агуулгад хөндлөнгөөс оролцох, эсвэл мэдээллийн аливаа эх сурвалжид нэвтрэх боломжийг хязгаарлах оролдлогоо зогсоох, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын авахыг хүссэн аливаа хүсэлт бүрт хариу өгөх үүргийг төрийн албан тушаалтнуудад ногдуулах зохицуулалт бүхий Мэдээллийн эрх чөлөөний болон Мэдээллийн нууц эх сурвалжаа хамгаалах үүргийг баталгаажуулсан хуулиудыг нэн даруй батлах,

ХМХ-ийн эзэд, эрхлэгчдэд:

Редакцийн цагдан хяналтыг хориглох, редакцийн хараат бус байдлыг хангасан гэрээг сэтгүүлчидтэйгээ нэн даруй байгуулж, төдий өдөр тутмын үйл ажиллагаанд оролцож, дарамт шахалт үзүүлэхээ зогсоох,

Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлд:

Хэвлэлийн эрх чөлөө, сэтгүүлчдийн эрхийг хамгаалах амин чухал үүрэг гүйцэтгэдэг хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын тогтолцоог хөгжүүлэхэд онцгой анхаарахыг уриалж байна.

Сэтгүүлчид ээ!

Мэргэжлийн эрхээ эдлэхдээ хүний эрхийг хүндэтгэн дээдэлж, мэргэжлийнхээ ёс зүйгээ баримтлан ажиллая.

УИХ-аас 2003 онд баталсан “Монгол Улсад хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөр”-ийн “Хүний суурь эрхийг хангах нь” хэмээх бүлгийн 2.2.4 хэсгийн заалтуудыг Монгол Улсын Засгийн газар эрчимтэй, үр дүнтэй хэрэгжүүлнэ гэдэгт бид найдаж байна.

*“Цагдан Хяналтын Эсрэг!!!”
Дугуй ширээний ярилцлагад оролцогчид батлав
2006 оны 05 сарын 02-ний өдөр
Улаанбаатар хот*

ОЛОН НИЙТИЙН ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Бүрэн шинэчлэгдсэн хөтөлбөрөөр нэвтрүүлгээ цацна

ОНРТ-ийн ерөнхий захирлыг 1-р сарын 26-нд томилсноос хойш тус телевизийн ажил хэрхэн өрнөж байна вэ? Телевизийн шатаар өгсөхөд 2006 оныг англи хэл эзэмших жил болгон зарласан лоозон хадсан нь нүдэнд шууд тусч байлаа. ОНРТ 4-р сарын 26-аас шинэчилсэн хөтөлбөрөөр нэвтрүүлгээ цацах бөгөөд гадаадын ОНРТ-ийн туршлагыг судалж, судалгааны багтай хамтран ажилласны дүнд тус телевиз 9-р сарын нэгнээс мөн Монголын радио 5-р сарын нэгнээс бүрэн шинэчлэгдсэн программаар нэвтрүүлгээ цацна гэж ОНРТ-ийн Ерөнхий захирал С.Мягмар яриу.

Дэлгэрэнгүйг www.globeinter.org.mn

Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн өнөөгийн байдал

1998 онд УИХ-аас баталсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль хэрэгжиж эхэлснээр төрийн өмчид байсан ХМХ болох радио, телевиз, сонин хэвлэлүүд орон нутгийн болон хувийн өмчид шилжиж, мөн үүнтэй зэрэгцэн олон тооны хувийн радио, ТВ байгуулагдаж орон нутагт хэвлэл мэдээллийн хэрэгсэл тогтмол үйл ажиллагаа явуулах боломж бололцоо бүрдсэн юм.

Ховд, Хөвсгөл, Дархан-Уул, Орхон аймгуудад 2-3 сонин, 4-5 хүртэлх радио телевиз орон нутгийн иргэдэд мэдээллээр үйлчилж байна. Хэвлэлийн хүрээлэнгийн хийсэн судалгаанаас харахад ХМХ-ийн тоогоор Хөвсгөл, Дархан-Уул аймгууд тэргүүлдэг байна.

2006 оны 2-р сарын 17-18-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо хуралдсан "Орон нутгийн хэвлэл мэдээллийн улсын анхдугаар чуулга уулзалт"-аас гурван чиглэл бүхий уриалга гаргасны нэгд: Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын /ИТХ/ дэргэд байгаа радио, телевизүүдийг ойрын үед менежментээр хувьчлах улмаар энэ саналаа холбогдох байнгын хороогоор дамжуулан УИХ-д уламжлахаар тогтсон билээ. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 58-р зүйл, Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 5-р бүлгийн 32-р зүйлийн 1-р заалтаас харахад: Орон нутгийн ХМХ-ийг менежментийн гэрээгээр хувьчлах, олон нийтийн өмчид шилжүүлэх, хувийн өмчид шилжүүлэн худалдах зэрэг нь Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу нээлттэй байгаа юм. Үүний дагуу ИТХ-ын дэргэд байсан радио, телевизүүдийн өмчийн харьяаллыг өөрчлөх үйл явц орон даяар өрнөөд байна. Манай бүсийн мониторингид Баян-Өлгий, Говь-Сүмбэр, Сүхбаатар, Өвөрхангай, Архангай, Говь-Алтай аймгуудад ИТХ-ын хурал нь орон нутагт олон нийтийн радио, телевиз байгуулах шийдвэр гаргаад байгааг мэдээлж байна. Баянхонгор аймагт менежментийн хувьчлал хийхээр тендер зарлаад байгаа бол Хэнтий, Дорнод аймагт хувьчлал амжилттай явагджээ.

Харин зарим аймагт, тухайлбал, Говь-Алтай аймгийн ИТХ-ын шийдвэрээр явуулсан менежментийн хувьчлалаар ХМХ-д он удаан жил ажилласан сэтгүүлч, уран бүтээлчид нь хувьчлан авсан боловч санхүүгийн бэрхшээлээс үүдэн үйл ажиллагаа нь зогсоод байгаа юм байна. Говь-Сүмбэр аймагт ИТХ-ын шийдвэрээр аймгийнхаа радио телевизийг олон нийтийнх болгож удирдах дээд байгууллагыг нь томилжээ. Харин орон нутгийн төсөвт радио, телевизийн төсөв тусгагдаагүй учраас Говь-Сүмбэр аймгийн олон нийтийн радио, телевиз мөн үйл ажиллагаагаа явуулж чадахгүй зогсчээ.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчийн хэлбэр ямар байхаас үл хамааран орон нутгийн ХМХ-үүд санхүүжүүлэгч талтай гэрээ байгуулах замаар редакцийн хараат бус байдлаа хамгаалан ажиллаж, аливаа улс төрийн хүчин, бизнесийн бүлэг, хувь хүний сонирхлоос ангид, орон нутгийн иргэдийн мэдээлэл хүлээн авах эрх, ашиг сонирхлыг дээдэлсэн үйл ажиллагаа явуулна гэдэгт манай байгууллага найдаж байгаа юм.

Тоймыг бичсэн: Төслийн зохицуулагч Ч.Ерөөлсүрэн

Баян-Өлгийн радио, телевизийн байдал

"Орон нутаг дахь хэвлэл мэдээлэл Хэвлэлийн эрх чөлөөний хуулийн дагуу зөв гольдролд ороод удаагүй байна. Хууль эрх зүйн орчин зөв үйлчилдэггүй, хэн нэгэн албан тушаалтан, улс төрийн намын хэт ноёрхлын талбар байсан гаж тогтолцоо ОНРТ-ийн тухай хууль батлагдсанаар эрүүлжих шатандаа ороод байна" гэж Баян-Өлгий аймгийн Мэдээлэл Технологийн Төв (МТТ)-ийн захирал Р.Сураган 2006 оны 4-р сарын 14-нд "Глоб Интернэшнл" төрийн бус байгууллагаас ЮНЕСКО-гийн санхүүжилтээр зохион байгуулсан "Хараат бус хэвлэл мэдээллийн ардчилсан нийгэмд гүйцэтгэх үүрэг" сэдэвт дугуй ширээний ярилцлагын үеэр тавьсан илтгэлдээ дурьдсан юм.

МТТ нь хуучин аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Хэвлэл мэдээллийн төв байсан бөгөөд аймгийн төсвөөс 27 сая төгрөг авдаг. МТТ хуучин "Жан Өмөр" сониныг сэргээн "Жан дауир" нэртэйгээр дахин хэвлэж эхэлжээ. Эднийх мөн телевизийн нэвтрүүлгээ сэргээн дамжуулахаар эхэж байгаа юм байна. Тэд мөн 2005 оны 5-р сарын 1-нээс 20 минутын нэмэлт нэвтрүүлэг бэлтгэн Монголын Үндэсний Радиоогийн сувгаар орон даяар нэвтрүүлэхээр удирдах хүмүүстэй тохиролцсон ажээ.

Баян-Өлгий аймгийн Радио өргөн нэвтрүүлгийн станц нь (РӨНС) нь 1965 онд байгуулагдсан боловч техник технологийн хувьд хуучирсан, 60 кВтын хүчин чадлын хэмжээнд хүрч ажиллаж чадахгүй байгаа ажээ. Мэдээлэл Харилцаа Технологийн Газрын харъяа Радио, телевизийн сүлжээний бүтцэд багтдаг энэ РӨНС өдөрт нэг цагийн казах хэлний өргөн нэвтрүүлэг цацах зорилготой. РӨНС-ийн техник технологийн шинэчлэлийг нэн даруй хийхгүй бол казах хэлний өргөн нэвтрүүлэг бүр зогсож, үндэсний цөөнхийн эх хэлээрээ мэдээлэл хүлээн авах эрх зөрчигдөнө гэж сэтгүүлч, инженер техникийн ажилтнууд санаа зовниж байгаа ажээ.

ОНРТ-ийн хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Баян-Өлгий аймгийн ИТХ-аас орон нутгийн олон нийтийн өргөн нэвтрүүлэг байгуулах дүрэм боловсруулж баталсан байна. Энэ дүрмийн дагуу Удирдах зөвлөл байгуулах асуудал өнөөдөр хүртэл сунжирсан байна. Саяхан аймгийн засаг дарга О.Хабсатар, МТТ-ийн захирал Р.Сураган нар МҮРТ-ийн удирдлагатай уулзаж Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг хэрэгжүүлэх УИХ-ын 1998 оны тогтоолын дагуу МТТ-ийг МҮРТ-ийн салбар болгохоор тохиролцож, удахгүй гэрээнд гарын үсэг зурах юм байна. МҮРТ-ийн захирал Б.Пүрэвдаш "МҮРТ Баян-Өлгий дэх салбарт арга зүйн туслалцаа үзүүлэх бөгөөд санхүүгийн, техник шинэчлэх хөрөнгө оруулалтын туслалцаа үзүүлж чадахгүй" гэж хэлсэн юм.

Одоо Баян-Өлгий аймагт телевизийн өргөн нэвтрүүлэг эрхэлж буй цорын ганц байгууллага нь 2006 оны 2-р сараас үйл ажиллагаа явуулж буй "Өлгий" телевиз юм. Эднийх долоо хоногийн хоёр өдөр тус бүр 3 цагийн нэвтрүүлэг дамжуулдаг байна. Мөн кабелийн сувгаар Улаанбаатар хотын телевизийн суваг бүрийг үзүүлж байгаа ажээ. Харин МҮРТ-ийн Маркетингийн албаны Баян-Өлгий аймаг дахь салбар, кабелийн телевизийн хооронд үзэгчдийн хураамжийн асуудлаар маргаан үүссэн ч өнөө хэр шийдвэрлэж чадсангүй.

Энэ маргааныг зохицуулах, мөн Баян-Өлгий аймагт олон нийтийн өргөн нэвтрүүлгийг зохион байгуулахдаа аливаа улс төрийн хүчин, бүлэг этгээд, хувь хүний сонирхлоос илүү гагцхүү иргэдийнхээ мэдээлэл хүлээн авах эрх, ашиг сонирхлыг дээдэлсэн шийдвэр гаргана гэдэгт "Глоб Интернэшнл" төрийн бус байгууллага итгэж байна.

Бэлтгэсэн: Тэргүүн Х.Наранжаргал



"Глоб Интернэшнл" ТББ-ын мониторингийн сүлжээний Баян-Өлгий аймаг дахь сурвалжлагчаар "Өлгий" ТВ-ийн ерөнхий редактор, Баян-Өлгий аймгийн Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлийн салбарын дарга И.Хуатай ажиллаж байна.

И.Хуатай нь 1972 оноос хэвлэл мэдээллийн байгууллагад тасралтгүй ажиллаж байгаа туршлагатай сэтгүүлч бөгөөд 1983 онд МУИС-ийн Сэтгүүл зүйн ангийг дүүргэжээ.



Баян-Өлгий аймагт хэрэгжүүлж буй "Үндэсний цөөнхийн мэдээлэл хүлээн авах эрхийг хөхиүлэн дэмжих нь" төслийн хүрээнд Казахстаны Аль-Фарабийн нэрэмжит Үндэсний Их сургуульд 2006 оны намрын семестрт дадлага хийхээр сонгон шалгарсан залуус:

1. З.Гүлбатиза, 2. Н.Совет, 3. Х.Айнур, 4. М.Соян
/баруун гар талаас/

Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй: энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана /Иргэний болон Улс Төрийн эрхийн тухай Олон Улсын пакт 19.2 дугаар зүйл/.

Соёлын гавъяат зүтгэлтэн
Хорлоогийн ЦЭВЛЭЭ

НИЙТЛЭЛИЙН ЖАМ ЁСОН

Жам ёс хэмээхийг бодит хууль, эсвэл зүй тогтол гэж нэрлэвэл илүү ойлгомжтой юм. Жам ёстой юм тэр ёсоороо байгаа цагт л оршин байх өгөгдөлтэй. Жам ёсон бүхнийг захирна. Жам ёсоороо байгаа нь оршино. Жам ёсоороо эс бол үл оршино.

Нийтлэл нийтлэлээрээ оршин байхын тулд зөвхөн өөрийнхөө дотоод жам ёсонд захирагдана. Булаг шандаас эх авч нуур далайд цутгадаг нь гол мөрний ёсон. Нэг өгүүлэмжээс эх авч утга санааг арвижуулсаар мэдлэг мэдээллийн их далайд өөрийгөө юүлдэг нь нийтлэлийн ёсон.

Нийтлэл бүр биеэ даасан тусгай нэгэн ертөнц. Тэд өөрийн жам хуулиар төрж хүний хорвоод орж ирнэ.

Нийтлэл бүхэн кино, жүжиг, өгүүллэг, тууж, яруу найраг шиг өөр өөрийн оноосон (нэр) гарчигтай, эхэлбэртэй, эх биетэй, дуусгавартай. Тэдгээр нь амьдрал дээр ус агаар шиг бэлэн байдаггүй учраас бичигч түүнийг бүтээлч сэтгэлгээний эрэл хайгуулаар олж авдаг. Хумсын чинээхэн мэдээнд ч эхэлбэр, дуусгавар, гарчиг байх. Аль нэг нь дутуу бол нийтлэл болж чадахгүй. Жижиг мэдээ, том тэмдэглэл, уран найрууллыг бичихийн аль нь сэтгэлгээний шинэ ертөнцийг туурвин бүтээж байгаа хэрэг мөн.

Тэдгээрийг дурын үгээр, эхэлбэргүй эсвэл дуусгаваргүй, санаан зоргоор жишээлбэл, “Байнга хөгжиж өдөрт өдрөөс орон Монгол” гэж бичих аргагүй. Заавал урьдчилан бодож, утга санаа онолдуулж, үг хэллэгийн сонголт хийж, дэс дараалалд оруулж, хооронд нь барьцалдуулж бүтээдэг. Хэрэв нэгэн эхээс хувилж тараасан биш бол нэг ижил үйл явдлаар бичсэн мэдээ хүртэл өөр өөрийн хувилбартай төрдөг.

Нийтлэл бүхэн ингэж тодорхой зохиогч эзний туурвил болж хорвоод мэндэлдэг учраас тэдгээрийг урлан бүтээх үйлийн эзэд-сэтгүүлчид нь уран бүтээлч хүмүүс мөн байдаг. Хүний хэлээгүйг хэлж, мэдээгүйг мэддэг нь сэтгүүлч хүний онцлох шинж. Товчхондоо бол сэтгүүлч зохиолчид өөрөөр сэтгэж, бас өөрөөр ярьдаг.

Ерийн уйтгарт амьдралыг ч ер бишийн сонирхолтой болгон бичиж туурвих монгол бичгийн арга мянга түм бий. Түүний нэг нь энгийн амьдралыг хүний санаанд оромгүй урнаар зураглаж бичих арга юм. Ажиглагтун.

1. “Хөдөөгийн байдал шалдар булдар, цагийн улирал ороо бусгаа, элстэй шанд, буттай цайдмыг дагаж хааяа нэг хар гэрээс утаа суунаглана.

Дөрвөн зүг цэв цэлийн уйтгартай, цагаан униар татна. Зуны лүгхийм халуун эсгий гэрийг шарж, малчин хүний сэтгэлийг бухимдуулна.

Айлын хаяагаар үхрийн баас үргэлжилжээ. Үүгээр түүгээр хэдэн тугал оодгонон давхина”

/Д.Нацагдорж “Хуучин хүү” өгүүллэгийн зураглал/

2. “... Дорно дахинд, манай эртний сударт Мэй улс гэж алдаршсан Америкийн Нэгдсэн Улсын Нью-Йорк хотын Кеннедийн нэрэмжит нисэх онгоцны олон улсын буудлын засмал зурвас руу бидний суусан «Ил-82» онгоц дорогшилж эхлэх тэр мөчид дороос маань үй түмэн илд жаднуудын хурц үзүүр сэрийж байх шиг харагдлаа. Нью-Йоркийг жигүүртний нисэх өндөрлөгөөс харахад анх ийм сэтгэгдэл төрнө. Тэдгээр илд жадны үзүүр нь дээшээ нарийссан хурц бөгөөд газарт ойртох тусам бүдүүрч харагдана. Онгоцны өвчүү өөд нэвт хатгах гэж бие биенээс өрсөлдсөн Нью-Йоркийн өндөр өндөр байшингууд газар дээрээс заналхийлэх мэт ер бусын сэтгэл төрүүлж онгоцон доогуур сэрийлдэн өнгөрч байлаа...”

/Л.Түдэв. “Нью-Йорк урт цацтай хот” нийтлэлийн эхэн хэсгээс/

3. “... Сая сая хүний цус нулимсыг ханхлуулан, зуу зуун жилийн буурал түүхийг агуулан, Аллах тэнгэрийн дор Арабын хөрснөө хүний гараар боссон Пирамидын хормойд амьдрал тэндэхийн өнгөөрөө үргэлжилсээр...”

Халуун цөлийн шар шороон дунд уй гуниг дүүрэн дүнсйх Пирамидынхаа хормой хотыг ороон газар газрын жуулчдын халаасыг Аллах тэнгэрээ аргалан байж, Араб хэлээ аялгуулан

байж тэмтрэх аргатай зальтай наймаачид нь хэдэн зуугаараа язганана. Каир ер нь зальтай хот.”

/Сэтгүүлч Б.Ганчимэг. “Өдрийн сонин” 2006.04.03 №080/

4. “Зуны халуунд их Цамбагарав уулын мөнх цас яаж тэсж үлдэв гэмээр норсон ёотонгийн өнгөтэй харагддаг. Гэлээ гэвч салхины үзүүр хонгиноод нарны өнгө зэгэлтээд ирэхийн үед Цамбагаравын мөнх цас тэлэн тэлсээр тал хөндийд өвлийг зарлаж, их уулсын дулаан өлгийд бөөр хаялсан Олоннуурын хөвөөг зайрмагтуулна. Зайрмаг, мөс болон хумисаар авч тамир нь алдарсан нуурын ус басхүү хүр хүр давалгаалан хүйтэн хөлдүү газраас гэтэж ирсэн зайрмаг мөстэй тэмцэнэ. Цаг нь болоод ирэхээр өвлийн ааш араншин чангарч хоног хоногоор газар дэлхийг ноёлох авай.

Өвлийн хүйтэнд Цамбагарав уулын мөнх цас огторгуйд сүр хүчтэй будран цайвалзаж, нуурын ус захаасаа автан хөлдсөөр голдоо өчүүхэн өрх үлдээжээ. Энэ өрх хумигдан хумигдсаар аньж, дүн өвөл болсныг зарлана. Хүний хөдөлмөр, малын чөмгийг сордог энэ улиралд Цамбагаравын хоньчин С.Цэдэнбал аль хавар хадны нөмөрт агт нүдлэх үеэс өвөлд бэлтгэж, базаасан тул сэтгэл тэнүүн явна.

/Цэндийн Доржготов. “Үнэн” сонины 1979 оны №333-т хэвлэгджээ./

5. “Холыг зорьсон нүүдэл. Гангийн зэгэл манан орчин тойрны уул толгод, тал хөндийг нэлэнхүйд нь бүрхэн, туниа муутай нар гийгүүлэх авч бөгчим халуун, амьд бүхний амьсгалыг давчдуулсан өдөр элсэнд дарагдаж үзүүрийн нь өргөст хэсэг муурын сахал мэт шөрвийх харганат хөндийг уруудан тэмээтэй хүн гэлдрүүлнэ. Ташаан толгойд нь хувин дүүжилж болмоор, бөх нь унаж, элэгдсэн хэт лугаа адил болсон хүрэн тэмээ унасан тэр хүн бие чацархаг бөгөөд лагс, харц хүрлэгэр, бодлогоширсон шинжтэй авч харин өмссөн, хэрэглэснийг нь харвал хээ шаагүй байрын эр байв аа...”

Нэгдлийн дарга Гэлэгийн Жамсран гэх эл эр зовхи хамхилгүй элдвийг эргэцүүлэн бодсоор дорноос шаргалтах үүрийн туяатай золгов.”

/Банзрагчийн Ламсүрэн “Үнэн” сонины 1974 оны № 280/

6. “Хорголжин хонх хүүхдийн бойтгонд шулганана. Баривч эсгэж суугаа эх хааш хааш нь дөрвөн хуруу тавьж эсгэнэ.

Час хийх хонх тахилын будаа нуртал цангинана. Буян ном сэтгэлд хурахуй мөргөлчид алга хамтатган залбирна.

Ширмэн хонх явган хаалганд үглэнэ. Гэрийн эзэгтэй домботой цай цогшуулна.

Харанга хүрэн дээгүүр гасална. Гуйлгачин алган дээр нулимс ойчно.

Орчлон дээгүүр мөнх бусын хонхон дуу дуурсана. Анир авсан мэргэд яаран яаран бэх цаасыг нийлүүлнэ. Хонхон дуу үл тасарна.

/Д.Батбаяр. “Амрагийн тэнгэр” УБ. 2000/

7. “Нар мандаж, нар шингэж, цаг улирч байна. Хүн төрөлхтөн яаж байна вэ? Хүн төрөлхтөн газар дэлхийд тэмцэн амьдарч байна... Хорьдугаар зуунд хүнийг энэрэх ёс, хүнийг үзэн ядах үзэл хөөр өөр өөрийн шинж чанараар эвлэршгүй харшилдаж ирлээ.

Хүн алимын мод цэцэглэхийг үзэж, шувуудын донгодохыг сонсох дуртай. Харин сөнөсөн тосгоны үнс чандруу, хагацлын эмгэнэл үзэх гэж орчлонд хүн амьдарч яваа биш ээ.

Түүхчдийн тодорхойлсноор, дайн дажин хүн нийгмийн хөгжлийг таван эрин үеэр ухраажээ. Энэ нь хэрэв дайтаагүйсэн бол өнөө бид XXV зууны үеийн хөгжлийн хэр хэмжээнд хүрсэн байх учиртай гэсэн үг.

Унан босон хөлд орж байгаа хүүхэд, цэцэг алагласан тал, хун суусан нуур, олон үеийн хүний бүтээсэн орд харш, хиймэл дагуул...”

/Банзрагчийн Жамд. “Үнэн” сонины 1970 оны №89/

Үргэлжлэл дараагийн дугаарт